



## 3 Нифай 27–4 Нифай 1

(10-р сарын 19–25)

**А**врагчийг нифайчуудад үзэгдсэнээс хойш “бүгдээр Их Эзэнд хөрвүүлэгдсэн” (4 Нифай 1:2) байсан тул тэд бараг 200 жил эв нэгдэлтэй, амар амгалан байв.


Нифайчуудын зөв шударга үйлдлүүдийн өөр ямар ямар жишээ байдаг вэ? Та 4 Нифай 1:2–15-ыг уншаад, дараах хоосон зайг олсон жишээ-нүүдээрээ бөглө.

- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_
- \_\_\_\_\_

### ЯРИЛЦЛАГА

- Нифайчуудын зөв шударга байсан үеийнх нь аз жаргалыг зөвт бус байсан үеийнх нь уй гашуутай харьцуул. Ялгааг нь тунгаан бодоод, Их Эзэнд илүү сайн хөрвөгдөх арга замуудыг ол.
- Та өөрийнхөө амьдралд сайжруулж болох нэг зүйлийг сонгож чадаа уу?
- Эдгээр нь хэрхэн таныг найз нөхөд, гэр бүлийнхэнтэйгээ болон Их Эзэнтэй илүү ойртуулж болох вэ?


# Жинхэнээсээ хөрвөгдөнө гэдэг нь юу гэсэн үг вэ?



### Аз жаргал ба эв нэгдэл

Нифайчууд зөвт үйлдлийнхээ ачаар аз жаргалтай, эв нэгдэлтэй байсан (4 Нифай 1:2–15-ыг үзнэ үү).

- Тэд бие биетэйгээ шударга, эелдэг харьцдаг байв.
- Тэд Христийн зарлигуудыг дагадаг байв.
- Тэд даруухнаар мацаг барьж, залбирдаг байсан.



### Гай зовлон ба хагарал

Харамсалтай нь, олон жилийн эв нэгдэл, аз жаргал үүрд үргэлжилсэнгүй. Эцэст нь нифайчууд Бурханы зарлигуудыг дагахаа больжээ (4 Нифай 1:24–31-ийг үзнэ үү). Ингэснээр тэд:

- Амин хувиа хичээсэн, бардам хүмүүс болсон.
- Санхүүгийн ашиг олохоор өөрсдийн сүмүүдийг байгуулсан.
- Христийн Сүмийг үгүйсгэсэн.

